



ИНД - 129

Иргэний Нисэхийн Дүрэм

Гадаадын агаарын тээвэрлэгч - Гэрчилгээжүүлэлт

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-129 нь Монгол Улсад аливаа дараалсан 28 хоногийн дотор 2-оос дээш хөөрөлт, эсхүл буулт үйлдэх, эсхүл Монгол Улсад дараалсан 365 хоногийн дотор 8-аас дээш хөөрөлт, эсхүл буулт үйлдэх гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь, нүүлгэн шилжүүлэлт, эсхүл эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт, эсхүл биеийн эд эрхтний тээвэрлэлтийг багтаасан эмнэлгийн түргэн тусламжийн зорилгоор гүйцэтгэдэг үйл ажиллагаанд хамаарахгүй.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-129-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-129, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт

2006 оны 01 сарын 16

Нэмэлт, өөрчлөлт 1

2010 оны 05 сарын 07

Нэмэлт, өөрчлөлт 2 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-129-ийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 129 А.8-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	5
129.1. Хамрах хүрээ.....	5
129.3. Тодорхойлолт.....	5
129.5. Гэрчилгээжих шаардлага	5
129.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт	5
129.9. Гэрчилгээ олгох.....	6
129.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх	6
129.13. Үйл ажиллагааны тодорхойлолт.....	6
129.15. Гэрчилгээний хугацаа	7
129.17. Үйл ажиллагааг зогсоох мэдэгдэл	7
129.19. Гэрчилгээ сунгах	7
В Бүлэг - Гадаадын агаарын тээвэрлэгч - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага	8
129.51. Зөвшөөрөл	8
129.53. Бататгах нислэг, эсхүл тест	8
129.55. Осол, зөрчлийг мэдээлэх	8
129.57. Ажилтны бүртгэл.....	8
129.59. Тоног төхөөрөмжийн бүртгэл	9
129.61. Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр	9
129.63. Гадаадын агаарын тээвэрлэгчийн Ерөнхий заавар	9
С Бүлэг - Гадаадын агаарын тээвэрлэгч - Үйл ажиллагааны шаардлага	11
129.101. Байнгын хэрэгжүүлэлт	11
129.103. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт	11
129.105. Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II).....	12
129.107. Аэродром ашиглах.....	12
129.109. Ослын байршил дамжуулагч	13

А Бүлэг - Ерөнхий зүйл

129.1. Хамрах хүрээ

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, энэ Дүрэм нь гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх дараах этгээдэд хамаарна:

- (1) Монгол Улсад аливаа дараалсан 28 хоногийн дотор хоёроос дээш хөөрөлт, эсхүл буулт үйлдэх; эсхүл
- (2) Монгол Улсад аливаа дараалсан 365 хоногийн дотор наймаас дээш хөөрөлт, эсхүл буулт үйлдэх.

(b) Энэ Дүрэм нь, нүүлгэн шилжүүлэлт, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт, эсхүл биеийн эд эрхтний тээвэрлэлтийг багтаасан эмнэлгийн түргэн тусламжийн зорилгоор гүйцэтгэдэг үйл ажиллагаанд хамаарахгүй.

129.3. Тодорхойлолт

Энэ Дүрэмд:

Гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа гэж Монгол Улсад байнга оршин суудаггүй этгээдийн гүйцэтгэдэг дараах агаарын тээврийн үйл ажиллагааг ойлгоно:

- (1) Монгол Улс руу, эсхүл Монгол Улсаас; эсхүл
- (2) Монгол Улс руу, эсхүл Монгол Улсаас, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хүрээнд гүйцэтгэх төлбөрт нислэгийн үйл ажиллагааг.

129.5. Гэрчилгээжих шаардлага

(a) Энэ Дүрмийн дагуу олгосон Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд болон түүний дагуу үйл ажиллагаа эрхлэхээс бусад тохиолдолд, аливаа этгээд энэ Дүрэмд хамаарах үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

129.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:

- (1) тухайн богино хугацаа нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд, төлөвлөсөн үйл ажиллагааг эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө САА 24129/01 маягыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ;
- (2) 129.13(b)-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтын дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлнэ;
- (3) 129.63-д шаардсан байгууллагын Ерөнхий зааврын Монгол Улс руу, Монгол Улсаас, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх үйл ажиллагаанд хамаарах хэсгийг хянуулахаар хүргүүлнэ;
- (4) 129.51-д шаардсан зөвшөөрлийн нотлох баримтыг хүргүүлнэ.

129.9. Гэрчилгээ олгох

Хэрэв Дарга дараах шаардлагыг хангасан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших эрхтэй:

- (1) тухайн хүсэлт гаргагч нь В Бүлгийн бүх холбогдох шаардлагыг хангасан байх;
- (2) тухайн хүсэлт гаргагч нь хувь хүн бол, тухайн хүсэлт гаргагчийн 129.63(1) болон (2)-ын дагуу томилогдсон удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүний шаардлага хангасан байх;
- (3) 129.51-д заасан ICAO-гийн тухайн Хэлэлцэн тохирогч улс нь тухайн санал болгож байгаа гадаадын агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд, Конвенцийн дагуу өөрийн чиг үүргийг хэвээр хадгалж чаддаг байх;
- (4) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

129.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд, тухайн гэрчилгээ эзэмшигчийн гүйцэтгэж болох гадаадын агаарын тээврийн үйл ажиллагааг тодорхой заана.

129.13. Үйл ажиллагааны тодорхойлолт

(a) Энэ Дүрмийн дагуу олгосон гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд энэ зүйлийн (b)-д заасан Үйл ажиллагааны тодорхойлолт дагалдах ёстой.

(b) Үйл ажиллагааны тодорхойлолт нь дараах мэдээллийг агуулсан байх ёстой:

- (1) тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны үндсэн баазын тодорхой байрлал;
- (2) хэрэв хаяг нь өөр бол, Дарга болон гэрчилгээ эзэмшигчийн хооронд мэдээлэл солилцох үүрэгтэй үндсэн харилцагчийн хаяг;
- (3) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх хаяг;
- (4) тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа эрхлэх бизнесийн бусад нэр;
- (5) ашиглахыг зөвшөөрсөн тухайн агаарын хөлгийн маяг;
- (6) зөвшөөрсөн тухайн үйл ажиллагааны төрөл;
- (7) нислэгийн чиглэл болон үйл ажиллагааны бүсийн зөвшөөрөл, хязгаарлалт;
- (8) ашиглах аэродром болон нөөц аэродромын нэр;
- (9) энэ Дүрэм, эсхүл бусад дүрмийн шаардлагаас чөлөөлөгдсөн аливаа нөхцөл;
- (10) тодорхой нөхцөл байдлыг шийдвэрлэхэд Дарга шаардлагатай гэж тогтоосон аливаа бусад зүйлс.

129.15. Гэрчилгээний хугацаа

- (a) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.
- (b) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ нь түүний хугацаа дуусах, эсхүл Дарга түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна.
- (c) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, хугацаа нь дууссан, эсхүл хүчингүй болгосон гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.
- (d) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь түдгэлзүүлсэн гэрчилгээг холбогдох баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлнэ.

129.17. Үйл ажиллагааг зогсоох мэдэгдэл

Энэ Дүрэмд хамаарах үйл ажиллагааг зогсоосон гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, үйл ажиллагаагаа зогсоосон тухайн өдрөөс хойш 30 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэнэ.

129.19. Гэрчилгээ сунгах

- (a) Гэрчилгээ эзэмшигч нь гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24129/01 маягтын дагуу гаргана.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан хүсэлтийг тухайн гэрчилгээнд заасан хүсэлт сунгуулах хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацаа заагаагүй бол, тухайн гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлнэ.

В Бүлэг - Гадаадын агаарын тээвэрлэгч - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

129.51. Зөвшөөрөл

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, Даргын хүлээн зөвшөөрөхүйц ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаас олгосон, тухайн санал болгосон үйл ажиллагааг Монгол Улсад, Монгол Улс руу, эсхүл Монгол Улсаас гүйцэтгэхийг тухайн эзэмшигчид зөвшөөрсөн хүчинтэй агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл түүнтэй дүйцэх баримт бичгийн эзэмшигч байна.

129.53. Бататгах нислэг, эсхүл тест

(a) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших, эсхүл нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт гаргагч нь, хэрэв Дарга шаардсан бол, аливаа холбогдох, тогтоосон шаардлагыг хангаж чадахаа Даргад нотлох зорилгоор бататгах нислэг, эсхүл тест хийнэ.

(b) Тухайн нислэг, эсхүл тестийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр гүйцэтгэнэ.

129.55. Осол, зөрчлийг мэдээлэх

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, түүний агаарын хөлөгт тохиолдсон болон Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан аливаа осол, эсхүл зөрчлийг ИНД-12-ын дагуу Даргад мэдээлэх журмыг тогтооно.

129.57. Ажилтны бүртгэл

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журмыг тогтооно:

- (1) Монгол Улсад байрладаг бөгөөд үндсэн ажилтнаар, гэрээгээр, эсхүл бусад хэлбэрээр ажилладаг дараах шаардлагад хамаарах этгээд бүрийн үнэн зөв бүртгэлийг Монгол Улсад хадгалах:
 - (i) хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд нь нисэхийн мэргэжлийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшсэн байх шаардлагатай этгээд;
 - (ii) Даргын шилжүүлсэн аливаа эрх, эсхүл үүргийг хэрэгжүүлж байгаа этгээд;
 - (iii) тухайн гэрчилгээ эзэмшигчийн олгосон аливаа эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд.
- (2) тухайн бүртгэл нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг агуулна:
 - (i) энэ хэсгийн (1)-д заасан этгээд бүрийн холбогдох туршлага, мэргэшил болон сургалт;
 - (ii) энэ хэсгийн (1)(i)-д заасан үнэмлэх, эсхүл зэрэглэлийн үйлчлэх хүрээ, хүчинтэй байдал болон ангилал;
 - (iii) энэ хэсгийн (1)(ii)-т заасан шилжүүлсэн эрх, үүрэг;

- (iv) энэ хэсгийн (1)(iii)-т заасан гэрчилгээ эзэмшигчийн олгосон эрх.
- (3) тухайн бүртгэлийг, дараах хугацаанаас хойш нэг жилийн хугацаагаар, эсхүл Дарга шаардсан урт хугацаагаар Монгол Улсад хадгална:
 - (i) тухайн этгээд нь үнэмлэх, эсхүл зэрэглэл шаарддаг үүрэг гүйцэтгэхээ зогсоосон, эсхүл
 - (ii) тухайн этгээд нь аливаа шилжүүлсэн, эсхүл олгосон эрхийг хэрэгжүүлсэн.

129.59. Тоног төхөөрөмжийн бүртгэл

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь:

- (1) тухайн гэрчилгээнд заасан үйл ажиллагааг гүйцэтгэхэд ашигладаг нислэгийн аюулгүй байдалд-эрсдэлтэй тоног төхөөрөмжид хийсэн тохиргоо, үзлэг шалгалт болон туршилтын дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэдэг болохыг бататгах журмыг тогтооно;
- (2) энэ хэсгийн (1)-д шаардсан мэдээллийн дэлгэрэнгүй бүртгэлийг, тухайн бүртгэсэн өдрөөс хойш 2 жилийн хугацаанд Монгол Улсад хадгална.

129.61. Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр

Энэ Дүрэмд хамаарах 10, эсхүл түүнээс дээш төлбөртэй зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа гүйцэтгэхээр санал болгож байгаа гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, ИНД-108-ын шаардлагыг хангасан аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

129.63. Гадаадын агаарын тээвэрлэгчийн Ерөнхий заавар

(а) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, түүний Ерөнхий заавар дараах мэдээллийг агуулсныг бататгана:

- (1) Монгол Улсад байрлаж ажиллах удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал болон нэрс;
- (2) тухайн гэрчилгээ эзэмшигч нь энэ Дүрэм, эсхүл бусад дүрмийн шаардлагыг хангаж байгааг бататгах үүрэг хүлээсэн удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал болон нэрс;
- (3) тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Даргатай шууд харьцах тэдний харицлагыг багтаасан, энэ зүйлийн (а)(1) болон (2)-т заасан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын үүрэг, хариуцлага;
- (4) гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж, үүрэг гүйцэтгэж байгаа ажилтнуудын байршил бүрийн үйл ажиллагааны цар хүрээний нэгдсэн тодорхойлолт;
- (5) энэ зүйлийн (а)(1) болон (2)-т заасан удирдах ажилтнуудын үүрэг хариуцлагын шугаман хамаарлыг энэ зүйлийн (а)(4)-т заасан байршил тус бүрээр харуулсан байгууллагын бүтцийн зураг;

- (6) энэ зүйлийн (а)(4)-т заасан байршил бүр дэх хүсэлт гаргагч байгууллагын ажилтнуудын бүтцийн нэгдсэн тодорхойлолт;
 - (7) байнга оршин суугаа Улсад байгаа үйл ажиллагааны үндсэн байршил, хамааралтай бол, үйл ажиллагааны болон техник үйлчилгээний үндсэн баазын байршил;
 - (8) хүсэлт гаргагчийн байгууллагад үндсэн хяналт тавих, тухайн иргэний нисэхийн эрх бүхий байгууллагатай холбоо барих мэдээлэл;
 - (9) дараах дүрмээр шаардсан журам:
 - (i) 129.55 - осол, зөрчлийн талаар;
 - (ii) 129.57- ажилтны бүртгэлийн талаар;
 - (iii) 129.59- тоног төхөөрөмжийн бүртгэлийн талаар;
 - (10) 129.61-д шаардсан тохиолдолд, агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр;
 - (11) Ерөнхий зааврыг баталдаг, хянадаг, түгээдэг, нэмэлт өөрчлөлт оруулдаг болон үнэлгээ хийдэг журам;
 - (12) энэ Дүрэмд хамаарах үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэхэд шаардлагатай бусад мэдээлэл.
- (b) Тухайн хүсэлт гаргагчийн, гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаанд хамаарах Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байхаас бусад тохиолдолд, Дарга хүсэлт гаргагчид гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгохгүй.

С Бүлэг - Гадаадын агаарын тээвэрлэгч - Үйл ажиллагааны шаардлага

129.101. Байнгын хэрэгжүүлэлт

(a) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь 129.13-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтыг дагаж мөрдөх үүрэгтэй.

(b) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) В Бүлгийн шаардлагыг байнга хангах ба стандартыг дагаж мөрдөх;
- (2) 129.7(3)-аар хадгалахыг шаардсан, гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын холбогдох хэсэг болон түүний Үйл ажиллагааны тодорхойлолтын 1-ээс доошгүй хүчинтэй хувийг, Ерөнхий зааварт заасан Монгол Улс дахь үйл ажиллагааны томоохон байршил бүрд хадгалах;
- (3) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан журам бүрийг дагаж мөрдөх;
- (4) тухайн ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай, гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын холбогдох хэсэг болон энэ Дүрмийн дагуу Даргын олгосон Үйл ажиллагааны тодорхойлолтыг ажилтан хэрэглэх боломжтой байлгах.

(c) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь 129.63-д шаардсан мэдээллийг багтаасан, тухайн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврыг Даргын шаардсан үед шалгуулахад бэлэн байлгах үүрэгтэй.

129.103. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

(a) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт Монгол Улс руу, Монгол Улсаас эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа гүйцэтгэх тухайн байгууллагын тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар, нэмэлт өөрчлөлт оруулдаг болохыг бататгах;
- (2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгаа ба Ерөнхий зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу хийгддэг болохыг бататгах.

(b) Хэрэв гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах аливаа өөрчлөлтийг хийхээр зорьж байгаа бол, Даргад урьдчилан хүсэлт гарган, зөвшөөрөл авсан байх шаардлагатай:

- (1) 129.63(a)(1)-ийн дагуу нэр дэвшсэн удирдах ажилтан, эсхүл ажилтнууд;
- (2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэдэг Монгол Улс дахь үндсэн байршил;

(3) тухайн гэрчилгээний дагуу Монгол Улс руу, Монгол Улсаас, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх ажиллагаатай холбоотой, үйл ажиллагааны цар хүрээ;

(4) 129.61-д шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр.

(c) Энэ зүйлийн (b)-д заасан аливаа өөрчлөлт хийх хүсэлтийг гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь САА 24129/01 маягтаар гаргах үүрэгтэй.

(d) Дарга, энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлт хийх үеийн, эсхүл хийсний дараах нөхцөлийг тогтоож болно.

(e) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)-д заасны дагуу Даргын тогтоосон аливаа нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(f) Хэрэв энэ зүйлийн (b)-д заасан аливаа өөрчлөлт нь гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол, тухайн гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

(g) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, Дарга нисэхийн аюулгүй байдал, эсхүл аюулгүйн хамгаалалтын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзсэн нэмэлт өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий заавартаа оруулах үүрэгтэй.

129.105. Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II)

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, MCTOW нь 5700 кг-аас их, эсхүл 19-өөс дээш зорчигчийн суудлын конфигурацитай, турбин-хөдөлгүүрт нисэх онгоцоор Монгол Улс руу, Монгол Улсаас, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэрт, тухайн гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэдэг нисэх онгоц нь FAA TSO-C119b-гийн шаардлагыг хангасан ACAS II-оор тоноглогдсон болохыг бататгах үүрэгтэй.

129.107. Аэродром ашиглах

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэдэг нисэх онгоц нь дараахаас бусад тохиолдолд, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа аэродромыг хөөрөлт, эсхүл буултад ашигладаггүй болохыг бататгах үүрэгтэй:

(1) тухайн аэродромд ашиглах ХБЗ бүр нь ИНД-139-ийн Хавсралт А.1-ийн дагуу төгсгөлийн аюулгүйн зурвасаар (RESA) хангагдсан; эсхүл

(2) хэрэв ХБЗ нь энэ хэсгийн (1)-д заасан ХБЗ-ны төгсгөлийн аюулгүйн зурвасгүй бол, гэрчилгээ эзэмшигч нь тухайн нисэх онгоцны хөөрөлт болон буултын үзүүлэлтийг, тухайн нислэгийн талбайн давж буух төгсгөлд 90м-тэй дүйцэх ХБЗ-ны төгсгөлийн аюулгүйн зурвас үлдсэн байхаар, тухайн ХБЗ-ны холбогдох зарлагдсан зайг багасгасан байдлаар тооцоолсон.

129.109. Ослын байршил дамжуулагч

(a) Нисэх онгоцоор агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-91.529(a)-г мөрдөх шаардлагагүй.

(b) ИНД-91.529(g)-г үл харгалзан, тухайн нисэх онгоц нь дараах шаардлагын дагуу тоноглогдсоноос бусад тохиолдолд, гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийг нисэх онгоцоор гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- (1) хэрэв тухайн нисэх онгоц нь 19-өөс дээш зорчигч тээвэрлэхээр зөвшөөрөгдсөн ба тухайн нисэх онгоцонд 2008 оны 07 сарын 01-нээс өмнө нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ анх олгосон бол, тухайн нисэх онгоцыг 1-ээс доошгүй автомат ELT, эсхүл аливаа төрлийн 2 ELT-ээр тоногдсон байх ёстой;
- (2) хэрэв тухайн нисэх онгоц нь 19-өөс дээш зорчигч тээвэрлэхээр зөвшөөрөгдсөн ба тухайн нисэх онгоцонд 2008 оны 07 сарын 01-нээс хойш нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ анх олгосон бол, тухайн нисэх онгоцыг дараах төхөөрөмжөөр тоногдсон байх ёстой:
 - (i) 2-оос доошгүй ELT-ээр тоногдсон байх ба эдгээрийн нэг нь автомат байх; эсхүл
 - (ii) 1-ээс доошгүй ELT-ээр тоногдсон байх ба тусламж шаардлагатай үед бие даан мэдээлэл дамжуулах чадлыг нь ашиглан үйл ажиллагаа эрхлэгч минутанд 1-ээс доошгүй удаа байрлалыг нь тогтоож чаддаг байх;
- (3) хэрэв тухайн нисэх онгоц нь 19, эсхүл түүнээс бага зорчигч тээвэрлэхээр зөвшөөрөгдсөн ба 2008 оны 07 сарын 01-нээс өмнө нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ анх олгосон бол, тухайн нисэх онгоцыг аливаа төрлийн 1-ээс доошгүй ELT-ээр тоногдсон байх ёстой;
- (4) хэрэв тухайн нисэх онгоц нь 19, эсхүл түүнээс бага зорчигч тээвэрлэхээр зөвшөөрөгдсөн ба 2008 оны 07 сарын 01-нээс хойш нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ анх олгосон бол, тухайн нисэх онгоцыг 1-ээс доошгүй автомат ELT-ээр тоногдсон байх ёстой;
- (5) тухайн нисэх онгоцонд суурилуулсан, эсхүл авч яваа ELT нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
 - (i) FAA TSO C -126-аар гэрчилгээжсэн байх; эсхүл
 - (ii) нисэхийн аюулгүй байдалтай холбоотой ICAO-гийн олон улсын стандартыг хангасан байх;
 - (iii) 406 мгц болон 121.5 мгц давтамжийн аль алин дээр, эсхүл ICAO-гийн олон улсын стандартаар шаардсан бусад давтамж дээр дамжуулах.

--oOo--